

**Засгийн газрын үйл ажиллагааны
2004 оны 7, 8 дугаар сарын товч мэдээлэл
/2004.07.01.-2004.08.25./**

Монгол Улсын Засгийн газраас 2004 оны 7, 8 дугаар саруудад эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх, цаг үеийн тулгамдсан асуудал, тухайлбал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажлыг шийдвэрлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2004 оны эхний 7 сарын төсвийн гүйцэтгэлийг нэгтгэхэд улсын нэгдсэн төсвийн нийт орлого 366.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 17.8 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 31.9 хувиар өссөн байна. Орон нутгийн төсвийн орлого 38.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 14.1 хувиар давжээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага 361.5 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зарлагын 94.8 хувийг санхүүжүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс 36.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, төлөвлөснөөс төсвийн зарлага 6.2 хувиар давж санхүүжигдлээ. Эхний 7 сарын байдлаар төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) 71.2 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 4.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлж, бага дунд боловсролын тогтолцоог 11 жилд шилжүүлэх, боловсролын шинэ стандартыг нэвтрүүлэх болон “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээ, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн гишүүн орнуудын цэргийн албан хаагчидтай хийх хамтарсан сургуулийн бэлтгэлийг хангах, Ардын хувьсгалын 83 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх болон бусад асуудлуудад анхааран ажиллав. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг явуулах зорилтын хүрээнд олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ба тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ, АНУ-д албан ёсны айлчлал хийсэн нь эдгээр улсуудад харилцах харилцаанд хамтын ажиллагааны бүрэн түншлэлийн шинэ үеийг нээлээ.

1. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО

Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл боловсруулахад төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас гаргах эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтот үзүүлэлтүүдийн тооцоо, мэдээллийн заавар, түүний маягтуудыг батлав. Ингэснээр тухайн жилийн ба дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцож, төлөвлөж байх албан ёсны журам тогтоолоо.

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 50 сая юанийн буцалтгүй тусламж олгох тухай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрт болон БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 5000 тн улаан буудайн буцалтгүй тусламж олгох тухай Солилцох захидалд талууд тус тус гарын үсэг зурав.

Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улааны урилгаар Бельгийн Вант Улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Сангийн сайд ноён Дидие Райндерс Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Хэлэлцээний үеэр Монгол, Бельги Улсын найрсаг харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ярилцаж, санал бодлоо солилцсон бөгөөд хоёр тал гааль, татвар, үнэт цаасны чиглэлээр хамтран ажиллахаас гадна уулзалт хэлэлцээг үргэлжлүүлж, харилцан мэргэжилтэн солилцох зэргээр нягт холбоотой ажиллахаар тохиролцов.

Европын холбооноос Монгол Улстай хамтран ажиллах “2004-2006 оны Ерөнхий хөтөлбөр”-ийг тохиролцож Монгол улсын Засгийн газар, Европын холбооны хооронд байгуулах Харилцан ойлголцлын баримт бичгийг боловсруулж хоёр талаас харилцан тохиролцов.

Улсын төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагуудын 2004 оны 7 дугаар сарын зарлагын мэдээгээр улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 7 дугаар сарын өр, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргав. Улсын хэмжээнд 8 дугаар сарын 1-ний байдлаар нийт авлага 3.6 тэрбум, өр 4.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын төсөвтэй шууд харьцдаг төсөвт байгууллагуудын 2004 оны 8 дугаар сарын төсвийн зарцуулалтын эрхийн баталгаа болон дэд баталгааг хянаж, BUMIS болон FREE BALANCE программд оруулан банкны төлбөр тооцоонд хяналт тавих бололцоог хангаж ажиллав. Улсын төсвөөс 8 дугаар сард 46.7 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээс халамжийн тэтгэвэрт 2.1 тэрбум төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 0.1 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын санд 3.7 тэрбум төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 293.6 сая төгрөг, цагаатгалын нөхөн олговорт 42.5 сая төгрөг олгосон байна. Орон нутгийн төсөвт олгох 8 дугаар сарын НӨАТ-ын тооцоог хийж, нийтдээ 29.3 сая төгрөгийн НӨАТ-ын буцаан олголтыг шилжүүлэв.

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан 441 гэрээг хянан зөвшөөрч, түүнд 43.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрх нээв. Улсын төсвийн 2004 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийтдээ 19.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт хийгдэж, үүний 54.0 хувийг эрчим хүч, зам, тээвэр, холбоо, аялал жуучлал, нийтийн аж ахуй зэрэг дэд бүтцийн салбарт; 26.0 хувийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт; 5.0 хувийг батлан хамгаалах, хил хамгаалал, нийгмийн хэв журам сахиулах салбарт; 15.0 хувийг бусад салбарт олгосон байна.

Олон улсын нягтлан бодогчдын холбооны Улсын салбарын хорооноос батлан гаргасан төсөвт байгууллагууд болон ашгийн төлөө байгууллагуудад мөрдөх улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын эмхтгэлүүдийг хэвлэх тендер зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, хэвлэлтийн ажлыг эхлүүллээ.

СЭЗЯ-наас НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн газартай хамтран “Гадаад өрийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх” сэдэвт семинарыг зохион байгууллаа. Семинарын үеэр зээл тусламжийн хөрөнгийг ашиглан төсөл хэрэгжүүлж байгаа холбогдох төрийн болон санхүүгийн мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, манай улсад байгаа гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан, Монгол улсын өрийн ойрын болон дунд хугацааны төлөв байдалд дүгнэлт хийн, тэдний саналыг өрийн удирдлагын стратегийн баримт бичигт тусгах, мөн тус яаманд суурилуулсан Засгийн газрын гадаад зээл, тусламж болон дотоодын дамжуулан зээлдүүлсэн зээлийг бүртгэх нэгдсэн мэдээллийн системийг улам боловсронгуй болгох чиглэлээр санал солилцлоо.

Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Шар шороон шуурганы төсөл хэрэгжүүлэх, мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нефть бүтээгдэхүүн импортлох асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

“Стандартчиллын чиглэлээр гарсан хууль, тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлаар холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Японы газрын тос, байгалийн хий, металлын корпорацитай Орхон аймгийн нутаг дахь Баруун Эрдэнэтийн талбайд геологи хайгуулын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж, төслийн ажлыг удирдах зөвлөлийг батлан хээрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэв.

Улаан-Овоогийн нүүрсний ордын лицензийг БНХАУ-ын компани нь гэрээнд заасан үйл ажиллагааг явуулаагүйн улмаас уг ордын лицензийг буцааж, “Эрдэнэт” үйлдвэрт олголоо.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсэд гаалийн хяналт тавих журам болон хилийн шалган нэвтрүүлэх журмыг боловсруулаад байна.

“Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Цагааннуур” тосгоны нийгэм, эдийн засаг, бизнесийн орчин, чөлөөт бүсийн байршил, талбайн хэмжээг тогтооход чиглэсэн судалгааг хийв.

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” сургалтын хөтөлбөрийг Монголд нэвтрүүлэх талаар өнөөг хүртэл хийсэн ажлыг бие даасан төсөл болж хэрэгжих хүртэл үргэлжлүүлэх зорилгоор төслийн орон тооны бус багийг байгуулав.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль болон нонеоль системийг хэрэглэх талаар 20 компанийг оролцуулан Эрдэнэт үйлдвэрт семинар зохион байгуулав.

ЮНИДО-гийн техникийн туслалцааны хүрээнд хөгжиж буй орнуудад үзүүлдэг “Стандарчилал хэмжилзүй, сорилт болон чанар” сэдэвт төсөлд хамруулах асуудлыг шийдвэрлэв.

Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөр хэрэгжиж буй аймгуудын ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээ авсан. Мөн хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх 4 аймгийн тендерт шалгарсан компаниудад санхүүжилт олгох гурван талын гэрээ байгуулав.

2. НИЙГМИЙН БОДЛОГО

1939 оны Халх голын байлдааны ялалтын 65 жилийн ойг тохиолдуулан уг дайнд оролцсон 300 гаруй ахмад дайчдад 200,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж нийт 64,4 сая төгрөгийн мөнгөн тусламжийг олголоо.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын үйл ажиллагааг цэгцлэх, жигдрүүлж, чанарыг сайжруулах, төрийн зүгээс үнэлгээ дүгнэлт өгөх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, магадлан итгэмжлэх зорилгоор халамж, асрамжийн төвийн журмыг шинэчлэн боловсруулав.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж, эрх зүйн актын эмхэтгэл” номыг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн үндэсний хорооны ажлын албанаас нийгмийн түншлэгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын ажлын хэрэгцээнд зориулан эмхэтгэж төвийн болон баруун бүсийн аймгуудад хүргүүлэв. Энэхүү эмхэтгэл нь мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн чиг үүрэг, арга зүйн удирдлагын тухай, мэргэжлийн түр сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт зэрэг эрхийн актын тухай танилцуулахад чиглэгдэв.

НХСХХ-ийн төслийн нэгжтэй хамтран “Ажилгүй ядуу хүмүүст зориулсан ур чадварын сургалт ба аж ахуй эрхлэлт” Баруун бүсийн аймгуудын сургалт семинарыг Улаангом хотноо зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд багш, зааварлагч, арга зүйч нарт модульд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах асуудлаар мэдээлэл өгч, сургах, ур чадварын дүн шинжилгээ ба сургалтын хөтөлбөр DACUM арга, хэрэгжилт, чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөр ба ажил үүргийн дүн шинжилгээ зэрэг сэдвээр сургалт явууллаа.

Тусгай зөвшөөрөл бүхий гадаадад ажиллах хүч гаргадаг 12 компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийхэд гадаадад ажиллахаар явж буй иргэнтэй 6 сараас 3,5 жилийн хугацаатай гэрээ байгуулж, эхний 3 сараас нэг жилд дадлагажих байдлаар 1, 3 дахь жилүүдэд мэргэшсэн хэмжээнд ажиллах чиглэлээр гэрээ байгуулан цалин хөлсийг олгохоор тусгажээ.

Тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгал

Оны эхний 7 сарын байдлаар нийгмийн даатгалын тэтгэвэрт 62,4 тэрбум төгрөг олгохоос хугацаанд нь бүрэн олгов. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 53,7 тэрбум төгрөг хуримтлуулахаас 60,9 тэрбум төгрөг оруулж, төлөвлөгөөг 113,4 хувиар биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын тэтгэврийн санхүүжилтэд 60,4 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 11,3 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санхүүжилтэд 2,4 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санхүүжилтэд 2,1 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын санхүүжилтэд 504,8 сая төгрөг, нийгмийн даатгалын эхний 7 сарын санхүүжилтэд нийт дүнгээрээ 76,7 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Нийгмийн даатгалын авлага 9,2 тэрбум төгрөг байгаагийн 8,3 тэрбум төгрөг нь аж ахуйн нэгж байгууллагаас, 900,4 сая төгрөг нь төсөвт байгууллагаас авах авлага байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тэтгэвэрт оны эхний 7 сард 3,9 тэрбум төгрөгийг 43853 хүнд, нийгмийн халамжийн тэтгэмжид 6,3 тэрбум төгрөгийг 117061 хүнд олгоод байна. Нийгмийн

халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 14880 хүн хамрагдаж 312,6 сая төгрөг, тахир дутуу иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд 12780 хүн хамрагдаж, 512,9 сая төгрөг, ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээнд 61849 хүн хамрагдан 1,3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 251978 хүнийг хамруулж, 13,2 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Түүнчлэн 1509 хүнд 53,3 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 10789 хүнд 223,6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмжийг Архангай, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Дархан-Уул аймгийн зарим сум, нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг хугацаанд нь олгож чадаагүй байна.

БОЛОВСРОЛ

Бага, дунд боловсролын талаар:

2004-2005 оны хичээлийн жилд сургуульд элсээгүй нийт 7 настай хүүхдийг цэцэрлэгийн бэлтгэл болон ЕБС-ийн “0” бүлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, эдгээр бүлэгт ажиллах 1800 багшид зориулсан сургалтыг аймаг, нийслэлийн дүүргүүдэд зохион байгуулав. Сургалтад зориулж “Цэцэрлэгийн “Бэлтгэл” бүлэг, ерөнхий боловсролын сургуулийн “0” бүлгийн сургалтын агуулга, арга зүйн зөвлөмж, “Математик”, “Монгол хэл”-ний сурах бичгийн “бэлтгэл” хэсэг, холбогдох зөвлөмжүүдийг хэвлүүлж, сургалтад хамрагдсан багш нарт өглөө.

Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг МСҮТ-ийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив болон дээд боловсрол эзэшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулав.

Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид суралцагчдаас төгсөх жилдээ “Монгол сайхан бичигтэн” уралдаанд эхний 4 байранд шалгарсан суралцагчдыг их, дээд сургуульд суралцах хугацааны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэхээр заасны дагуу уг уралдаанд шалгаран МУИС, Боловсролын их сургуульд элсэн суралцаж байгаа 4 суралцагчийн сургалтын төлбөрийг сургалтын төрийн сангийн зардлаар санхүүжүүлэх эрхийн бичиг олголоо.

Боловсролын салбарыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлогын хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, бага дунд боловсролын тогтолцоог 11 жилд шилжүүлэх, хүүхдийг 7 настайгаас нь сургуульд сургах, боловсролын шинэ стандартыг нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд 2005 онд санхүүжих хүүхдийн дундаж тоо ЕБС-д энэ оныхоос 15.0 мянган, хүүхдийн цэцэрлэгт 7.0 мянган хүүхдээр тус тус нэмэгдсэн. Үүнтэй уялдан ЕБС болон цэцэрлэгийн 2005 оны төсөвт зардал нь УИХ-аар батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлээс 12.8 сая төгрөг буюу 9.1 хувиар өсөөд байна. Соёл, шинжлэх ухааны салбарын цалингаас бусад зардлыг инфляцийн түвшинтэй уялдуулж 5 хувиар нэмэгдүүлэн гаргалаа.

“Харааны согогтой хүүхдийн сургууль байгуулах тухай” БСШУ-ы сайдын тушаал гаргаж, уг сургуулийг 29 дүгээр сургуулиас тусгаарлан бие даасан 116 дугаар тусгай сургууль болгон байгуулав.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд хичээлийн шинэ жилийн эхний хичээлийг “Миний гэр бүл” сэдвээр явуулахаар шийдвэрлэж, Хүүхдийн төлөө Үндэсний газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Дэлхийн зөн /Монгол/ олон улсын байгууллагатай хамтран уг хичээлийг заах арга зүйн зөвлөмжийг боловсруулан 20000 хувь хэвлүүлж, сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэв.

Олон улсын математикийн 45 дугаар олимпиадад Монголын баг оролцож, 3 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, багаараа 87 орноос 19 дүгээр байр эзэлж амжилт гаргасан сурагчдын их, дээд сургуульд суралцах хугацааны сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангаас гаргахаар шийдвэрлэв.

Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар:

Төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын ангилалыг тогтоож мөрдүүлээ.

БНТУ-ын Үндэсний боловсролын сайд Хусейн Челик тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулав. Айлчлалын үеэр “Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газрын хооронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах Хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газрын хооронд Боловсролын үнэмлэх, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Протокол”-д гарын үсэг зурж баталгаажуулав. Туркийн тал одоо хүлээн авч байгаа 35 оюутан, 15 магистрант дээр нэмж 8 оюутан, 2 магистрант хүлээн авахаар болов.

Засгийн газрын тогтоолоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжаар (2004-2005 оны хичээлийн жилд шинээр элсэх оюутнуудад зориулж) суралцах оюутны хяналтын тоог БСШУ-ы сайд, СЭЗ-ийн сайдын хамтарсан тушаалаар баталлаа.

БСШУ-ны сайдын тушаалаар 2004 онд математик, хими, физик, биологи, газарзүй, мэдээлэлзүй, техник технологийн болон олон улсын олимпиадад I-III байр эзэлсэн 65 сурагчдын сургалтын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэлээ.

Соёл, урлагийн талаар

Аймаг, нийслэлийн музейн эрхлэгч, захирал нарт зориулан “Соёлын өвийг хамгаалахад музейн үүрэг” сургалт-семинарыг зохион байгуулж, Эрдэнэ зуу музейн гол зууг сэргээн засварлах ажлыг хүлээн авлаа.

“Уртын дуугаа дээдлэн дэлгэрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гаргуулж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхэллээ.

Халхын голын 65 жилийн ойн баярын хүндэтгэлийн концерт, Энэтхэгийн Одиссей чуулгын тоглолт, Италийн хөгжимчдийн тоглолт зэрэг урлагийн арга хэмжээнүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулав.

ЭРҮҮЛ МЭНД

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар авсан арга хэмжээ

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, 2004 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх журам”, “Эмийн гаж нөлөөг мэдээлэх хуудас”-ны загварыг баталж, хэрэгжүүлж байна.

Клиникийн нэгдсэн II эмнэлгийн компьютерийн дотоод сүлжээг өргөтгөх, эмнэлгийн цахим мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор ДЭМБ-ын төслөөр ирсэн болон ЭМЯ-нд ашиглагдаж байсан 12,4 сая төгрөгийн үнэ бүхий 8 төрлийн техник хэрэгслийг клиникийн нэгдсэн II эмнэлэгт олголоо.

Төвлөрсөн төсвийн хөрөнгөөр 2004 онд сумдад шинээр барих эмнэлгийн барилга болон харьяа байгууллагын их завсарын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн шалгаруулалтын хэмнэгдсэн хөрөнгөнөөс Өвөрхангай аймгийн Уянга сумын эмнэлэгт 7,2 сая төгрөг, Сэтгэцийн эмгэгийн клиникийн 29 ортой эмнэлгийн барилгад 15,3 сая төгрөгийг шилжүүлэн санхүүжилт хийхээр болов.

НҮБ-ын ХАС-гийн “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” дэд хөтөлбөр, ДЭМБ-ын “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” төслийн шугамаар захиалан авсан 22,4 сая төгрөгийн үнэ бүхий 10 нэр төрлийн эмнэлгийн багаж төхөөрөмжийг 8 аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгоод байна.

ДЭМБ-ын “Эрүүл мэндийн мэдээлэл ба бодлогын баримт бичиг” төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгт мэдээллийн дотоод сүлжээ байгуулах зорилгоор 22 компьютер, бусад тоног төхөөрөмжийг хуваарилан олголоо.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ

“Зонхилон тохиолдох халдварт өвчний стандарт” сэдэвт семинарыг аймаг нийслэлийн халдвар судлагч, халдварын эмч нарын дунд зохион байгууллаа.

Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тахлаас сэргийлэх 24 цагийн постыг 7 дугаар сарын 30-наас эхлэн 10 дугаар сарын 1-ныг дуустал ажиллуулж байна.

Вакцин дархлаажуулалтын Глобал Альянстай хамтран тавт вакциныг дархлаажуулалтанд нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тавт вакциныг 2005 оны 1 дүгээр сараас эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж байгаа бөгөөд ХӨСҮТ-д тавт вакцин хариуцсан орон тооны мэргэжилтэнг ажиллуулахаар болов.

Өвөрхангай аймгийн Батцэнгэл суманд гарсан балнад өвчний голомтод Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэргэжлийн группийг ажиллуулж, халдвар эсэргүүцэх арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.

8 дугаар сарын 1-ний байдлаар Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж Улаанбаатар хотод 82,0%, орон нутагт 85,0%-тай байна.

Оны эхний 7 сарын байдлаар 26196 эх амаржиж, 26141 амьд хүүхэд төрсөн байна. Энэ хугацаанд 25 эх эндсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 12 тохиолдлоор буурчээ.

0-1 насны 594 хүүхэд эндсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 22-оор, сүүлийн 5 жилийн дунджаас 183 тохиолдлоор буурав.

1-5 хүртэлх насны 165 хүүхэд эндэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 49 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 82-оор буурлаа.

3.БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Өмнөд говийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны харьяа говийн бага дархан цаазтай газрын Б хэсэг, Өмнөговь аймгийн Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт Сүүж уулын орчим хууль бусаар алт олборлосон зөрчил гарч буй газарт 7 дугаар сарын байдлаар хулгайгаар алт олборлохыг завдсан 24 удаагийн үйлдлийг илрүүлэн газар дээр нь зогсоох арга хэмжээ авлаа.

Монгол Улсын Засгийн газрын “Идлэг шонхор хамгаалах зохистой ашиглах тухай” тогтоолын дагуу 2004 онд экспортонд гаргах идлэг шонхорын гэрээг хийж дууслаа.

Филиппини Улсын Манила хотод CITES Азийн бүсийн зөвлөгөөн, Бээжин хотноо Зүүн хойд Азийн шар шороон шуурганы төслийн хурал, Хятадын Урулин хотод болсон Алтайн бүс нутагт хил дамжсан шим мандлын нөөц газар байгуулах техник эдийн засгийн үр дүнг хэлэлцэх 4 улсын уулзалт, Казахстан Улсын Астана хотод болсон Ази Номхон далайн бүс нутгийн Байгаль-орчин-хөгжил чуулган, Арабын Эмират хотод болсон шонхор шувууны ашиглалтын талаарх зөвлөгөөн зэрэгт оролцож, санал солилцлоо.

Усны тухай хуулийг шинэчлэн, өөрчлөлт оруулсантай уялдуулан “Голын гольдиролд өөрчлөлт хийх зөвшөөрлийн журам”-ыг боловсруулан батлуулсны дээр энэхүү журмыг хэрэгжүүлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагын эрхийг олгов.

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монгол Улс дахь ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах нь” төсөл хэрэгжүүлэхээр Японы Байгаль орчны сайдтай тохиролцлоо.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд мод үржүүлэг, ойжуулалтын ажлыг сурталчилсан семинар үзүүлэх сургуульд аймгуудын Байгаль орчны алба, ойг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага аймгийн ЗДТГ, Тужийн нарсны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, ой ан төв зэрэг байгууллагатай хамтран зохион явууллаа. Уг арга хэмжээнд 17 аймаг, нийслэлийн ойг нөхөн сэргээх, ойн аж ахуйн арга хэмжээг эрхлэн явуулдаг 30 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 160 гаруй хүн оролцов.

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн хог хаягдлын менежментийг орчин үеийн шинэ технологээр ангилан булах байгууламж барих талаар Тайланд Улстай хамтран ажиллах талаар тохиролцоод байна.

Шинжлэх ухаан технологийн сангаас хэрэгжүүлсэн “Богдхан уулын экосистем”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг боловсронгуй болгох аргазүй” зэрэг 2 төслийг ШУТ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталлаа.

Монгол Улсад “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокольмын конвенцийн хэрэгжилтийг түргэсгэхэд дэмжлэг үзүүлэх” сэдвээр Даян дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран семинар зохион байгууллаа. Уг семинараар “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хууль тогтоомжийн чадавх, зохицуулах байгууллагуудын үүрэг хариуцлага, удаан задардаг органик бохирдуулагчийг бууруулах улмаар зогсоох чиглэлээр санал солилцов.

Үйлдвэрлэлийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэгт таван цэвэрлэх байгууламжийн орох гарах 10 сорьц авч бохирдлын болон химийн задлан шинжилгээ хийв. Орчны цацрагийн хяналтын цэгүүдээс тунадас тоосонцрын 110 сорьц хүлээн авч цацраг идэвхийн хэмжилт хийлээ.

Энэ сард зохиосон хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээний дундаж таарц 91,9 хувьтай, нарийвчилсан мэдээний дундаж таарц 90,8 хувьтай байна.

4. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХӨДӨӨ АЖ АХУЙ

ОХУ-ын Хөдөө аж ахуйн академийн Сибирийн салбарын ерөнхийлөгч П.Л.Гончаров тэргүүтэй төлөөлөгчид мөн Тайванийн Бордооны корпорацийн дарга тэргүүтэй төлөөлөгчийг хүлээн авч хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулав.

“Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулав. Тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр ХХАА-н сайдын албан даалгавар гаргаж, аймаг орон нутагт хүргүүлэв. Аймаг нийслэлийн Засаг дарга нартай цаг үеийн ажлыг эрчимжүүлэх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар 8 дугаар сарын 5-ны өдөр телефон хурал хийж, “Аймаг, нийслэлийн Засаг дарга нараас тавьсан санал, хүсэлт ийг шийдвэрлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХХАА-н сайдын албан даалгавар гаргаж хэрэгжүүлж байна. Ургац хураалт, хадлана тэжээлийн бэлтгэл ажилд шаардагдах шатах тослох материалын хүрэлцээ хангамжийн тооцоог урьдчилан гарагж, ургац хураалтын явцад шатахууны тасалдалт гаргуулахгүй байх арга хэмжээ авч байна.

“Ган зудаас хамгаалах хөтөлбөр”, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд хадлангийн техник, трактор, гребицид, услалтын систем, хүлэмж нийлүүлэх ажлыг зохион байгуулав.

Сүхбаатар аймгийн 4 суманд хими, биологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцсэн ажлын дүнг УМХГ-ын Байгаль орчны хяналтын албатай хамтран шалгалт хийсэн дүнг хэлэлцэн, хангалттай гэсэн үнэлгээ өглөө.

Израилийн МАШАВ байгууллагатай хамтран “Усалгааны системийн загвар” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

“Цагаан идээ – эрүүл мэнд” өдөрлөгийг Нийслэлийн Засаг даргын ажлын алба, Монголын Хүнсчдийн холбоотой хамтран зохион байгуулав. “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”, “Хүнсний болон техникийн зориулалттай спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалтанд хяналт тавих журам”-ыг батлан мөрдүүлж байна.

ДЭД БҮТЭЦ

Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн нислэгийн чиглэлүүдийг зөв зохистой хуваарилах, аэродромуудыг засаж засварлах ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа болно. Хатгал нисэх буудлын хөөрч буух засварыг шинэчлэн засварлах ажлыг дуусган ашиглалтанд хүлээн авав. Ан-24/26, Фоккер-50 агаарын хөлгүүд аэродромын аливаа хязгаарлалтгүйгээр нислэг үйлдэх боломжийг бүрдүүллээ.

Замын-Үүдийн боомтын ажиллагааны талаар иргэд, байгууллагаас тавьсан санал гомдол зэргийн дагуу Хил хамгаалах ерөнхий газрын удирдах ажилтнууд тус боомтод ажиллаж, байдлыг газар дээр нь үзэж шалгасан илтгэлтэй танилцаж, байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, хамтран ажиллах талаар Тээврийн газар, Хил хамгаалах ерөнхий газарт мэдэгдэв.

Монголын хувийн автобусны эзэд-жолооч нарын холбооноос Нийслэлийн зам, тээврийн газрын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал ирүүлснийг шалгаж холбогдох зөрчлийг арилгуулах арга хэмжээг авлаа.

БНХАУ-ын Засгийн газрын 50 сая юанийн буцалтгүй тусламжийн хүрээнд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх хэлэлцээрийн дагуу төслийн хүрээнд нийлүүлэх 20620 нарны цахилгаан үүсгүүрийг хүлээн авч, нэг бүрийн үнийг тогтоосон. Одоогийн байдлаар аймгуудаас ирүүлсэн захиалганы дагуу 15 мянга гаруй нарны цахилгаан үүсгүүрийг аймаг сумуудад хуваарилан хүргүүлээд байна.

Улаанбаатаар хотын 1000 м-ийн голчтой дулааны шугам, Булган-Мөрөнгийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөг хүлээн авлаа.

Тайширын УЦС-ыг барих гүйцэтгэгчээр шалгарсан компаниудтай гэрээ байгуулан, барилгын ажлыг эхлүүлэх асуудлыг шийдвэрлэснээр эрчим хүчний нэгдсэн системийн нэг чухал асуудал шийдвэрлэгдэх боломж бүрдлээ.

Дизель станцтай 4 аймгийн эрчим хүчний хангамж, дизель цахилгаан станцтай аймгуудын алдагдлыг бууруулах, эдгээр аймгуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар авах асуудлыг шийдвэрлэн, тэдгээрийн түлшний зөрүү 310 сая төгрөг, засвар үйлчилгээний 297 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргуулахаар болов.

Хөвсгөл нууранд аялагч, жуулчдад үйлчилгээ үзүүлдэг усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд аж ахуйн нэгж, байгууллагын болон хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 19 хүнд усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулав.

“Discover Mongolia” жилийн ажлын хүрээнд Горхи-Тэрэлжийн тусгай хамгаалалттай газар нутагт байрлалтай “Мираж” жуулчны баазын хажууд “Жуулчин” ХК-ний хамт бэсрэг наадам зохион байгуулсан ба Франц, Герман, Япон зэрэг орнуудаас 100 гаруй жуулчин оролцов.

“Онъсон тоглоомын гайхамшиг”, “Чингис хааны нутгаар хийх морин аялал, соёлын сан”, “Загас тур” зэрэг олон улсын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь гадаад, дотоодын жуулчдыг татахад ач холбогдолтой боллоо.

5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

БАТЛАН ХАМГААЛАХ

Иракт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийг солих, Халх голын ялалтын 65 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлуудыг шийдвэрлэв. “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн 3 дугаар ээлжийн бүрэлдэхүүнийг Иракт илгээв. “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй манай цэргийн багийн бүрэлдэхүүн “Чарли” баазад үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Манай цэргийн багийн гүйцэтгэж байгаа бааз руу Иракийн сөрөг хүчнийхэн довтолж болзошгүй байгаа тул тэд байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжин, харуул хамгаалалтаа чангатган ажиллаж байна.

Монгол Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улстай хамтран НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн дөрвөн улс /АНУ, БНХАУ, Франц, Их Британи/ оролцсон олон улсын энхийг дэмжих ажиллагааны хамтарсан дадлагыг манай улсад олон улсын цэргийн багууд оролцсон тактикийн хамтарсан дадлагыг анх удаа зохион байгуулав.

Гадаад улсуудаас манай улсад суугаа болон хавсран суугаа батлан хамгаалахын атташе нарын танилцах аялалыг зохион байгуулав.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг АНУ-ын Аляск муж улсад олон улсын цэргийн нисэх хүчний хамтарсан “Кал Тандэр” хээрийн сургуульд амжилттай оролцлоо. Агаарын

довтолгооноос хамгаалах цэргийн баг ийнхүү анх удаа олон улсын цэргийн нисэх хүчний хамтарсан дадлагад оролцлоо.

Монгол Улс, АНУ-ын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд Номхон далай дахь АНУ-ын цэргийн ерөнхий командлагч адмирал Томас Фарго, БНСУ-ын Хуурай замын цэргийн штабын дарга Нам Жай Жун нар манай улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч болон Батлан хамгаалахын сайдад бараалхаж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргатай хэлэлцээ хийв.

Монгол Улс, ХБНГУ-ын Батлан хамгаалах яам хоорондын зөвлөлдөх уулзалт Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлагчийн орлогч, Израиль, Япон Улсын батлан хамгаалахын атташегийн айлчлалыг зохион байгуулав.

“Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”, “Дүрэмт хувцасны техникийн шаардлага, нөхцөл”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай журын төслийг батлан, хэрэгжүүлж байна.

Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлагч Стефан Том Монгол Улсад айлчилж, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвтэй танилцлаа.

ГАДААД ХАРИЛЦАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-д төрийн айлчлал хийлээ. Айлчлалын үеэр харилцан визээс чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Макаогийн Засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламж олгох тухай хэлэлцээр, Монгол банк, Хятадын Ардын банк хооронд хилийн худалдаа, төлбөр тооцооны тухай зэрэг хэлэлцээрүүдийг байгуулав.

Ерөнхийлөгч Н.Багабанди АНУ-д албан ёсны айлчлал хийсэн нь хоёр талын харилцаанд хамтын ажиллагааны бүрэн түншлэлийн шинэ үеийг нээлээ.

УИХ-ын даргын урилгаар Бельгийн Парламентын төлөөлөгчдийн Танхимын дарга тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчлав. Айлчлалын үеэр “УИХ, Бельгийн Парламентын төлөөлөгчдийн Танхимын хоорондын хамтын ажиллагааны Протокол”-д гарын үсэг зурав. Монгол дахь Бельгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх, монгол оюутнуудыг бельгийн их, дээд сургуулиудад суралцуулах зэрэг асуудлаар дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахаа төлөөлөгчид илэрхийлэв.

Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээнд манай улс нэгдэн орох чармайлт тавьж ирсний дүнд уг байгууллагын гишүүн орнуудын сайд нарын уулзалтаас манай улсыг гишүүнээр элсүүлэхээр шийдвэрлэв.

БНХАУ-д болсон Дэлхийн Өвийн хорооны ээлжит чуулганаар Орхоны хөндийн түүх дурсгалын газрын дэлхийн соёлын өвд соёлын ландшафт зэрэглэлээр албан ёсоор бүртгэснээр Монгол Улсын Засгийн газар, ЮНЕСКО-гийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны харилцан ойлголцлын баримт бичигт заагдсан нэг тодорхой асуудал биеллээ оллоо.

Германы Бундестагийн эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн Байнгын хорооны дарга Р.Краузе, Бельгийн Сангийн сайд, Японы Парламентын доод танхимын төлөөлөгчид, БНСУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, БНСУ-ын Хуурай замын цэргийн командлагч, БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд нар манай улсад тус тус айлчлав.

Зүүн хойд Азийн эдийн засгийн бага хурлыг зохион байгуулах хорооны хурлыг Япон дахь Зүүн хойд Азийн эдийн засгийн судалгааны институттэй хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулав.

БНСУ-ын “Күгмин Илбо” сониныг үндэслэгч, “Сынбогым” сүмийн хамба Жо Ён Ги манай улсад зочилж, хэвлэл мэдээллийн чиглэлээр хамтран ажиллах, оюутан авч сургах, харьяа сургуулийн салбарыг Монголд нээх талаар ярилцав.

Туркийн олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөтөлбөр зохицуулалтын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг соёрхон батлуулав.

6. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

Засгийн газрын хуралдаанаар Архивын улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай, хөрөнгө гаргах тухай /Марубени корпорацитай холбоотой/ Засгийн газрын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын хуралдаанаар хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа бөгөөд Ашгинь бус байгууллагын тухай хуулийн төсөл, Эрүүгийн байцаан шийтгэх нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг бусад яамнаас санал авахаар бэлэн болгоод байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуулийн төсөл, үндэсний олон нийтийн радио телевизийн тухай, Бооцоот болон мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Түүнчлэн Гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл, Цэрэг, цагдаагийн албан хаагчийн энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд санал өглөө. Мөн Эдийн засгийн гадаад харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг баталлаа.

“Мон-1847” тоот гэрээний дагуу Гаалийн болон нэмэгсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, “Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ы Эрээн хотод Консулын газар байгуулах тухай” УИХ-ын тогтоолын үзэл баримтлалыг баталлаа.

ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Цэрэндорж НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шугамаар Монгол Улсад ажилласан Норвегийн Осло дахь Засаглалын төвийн төлөөлөгч Сүдэйр Жан, Юү Ким нарыг хүлээн авч уулзан, Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын V бага хурлын мөрөөр Монгол Улсад ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийг боловсруулах асуудлаар ярилцаж санал бодлоо солилцлоо.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР